

МӨНГӨНИЙ ТОЙМ

/2014 оны 2 дугаар сар/



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2013				2014	
	09-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар	2-р сар
Инфляци						
Улаанбаатар хотын инфляци						
сарын	1.2	1.3	1.3	1.8	1.7	1.0
оны эхнээс	7.6	9.0	10.3	12.3	1.7	2.8
жилийн	8.4	9.5	11.1	12.3	12.2	12.0
Суурь инфляци						
сарын	1.4	2.8	1.2	1.3	0.7	0.3
оны эхнээс	6.4	9.4	10.7	12.1	0.7	1.0
жилийн	8.1	9.4	11.0	12.1	12.6	13.1
Улсын инфляци						
сарын	1.4	1.4	1.3	1.3	1.7	0.9
оны эхнээс	8.2	9.7	11.1	12.5	1.7	2.7
жилийн	9.9	10.8	12.0	12.5	12.3	12.2
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр	8 481.9	8 715.9	9 101.4	9 451.0	10 027.9	9 847.8
сарын өөрчлөлт, %	0.9	2.8	4.4	3.8	6.0	-1.8
жилийн өөрчлөлт, %	19.3	22.2	29.4	24.1	36.6	36.1
Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр	6 465.2	6 777.7	7 274.5	7 367.6	8 064.6	8 092.6
сарын өөрчлөлт, %	0.1	4.8	7.3	1.3	9.5	0.3
жилийн өөрчлөлт, %	18.5	22.0	32.8	27.5	40.0	40.6
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр	875.0	824.8	803.9	841.1	894.3	756.6
сарын өөрчлөлт, %	0.8	-5.7	-2.5	4.6	6.3	-15.4
жилийн өөрчлөлт, %	17.3	14.9	11.3	1.5	20.5	12.0
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр	2 943.1	2 643.7	2 823.2	3 335.6	2 957.5	3 131.1
сарын өөрчлөлт, %	13.1	-10.2	6.8	18.1	2.3	5.9
жилийн өөрчлөлт, %	22.4	23.1	26.9	54.0	54.3	37.9
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	10 153.4	10 488.8	10 822.4	10 769.3	11 014.9	11 153.9
сарын өөрчлөлт, %	3.8	3.3	3.2	-0.5	2.3	1.3
жилийн өөрчлөлт, %	47.9	53.0	57.6	54.1	54.3	55.6
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар	5.29	5.34	5.29	5.26	5.28	5.36
Хуу						
Хадгаламжийн ЖДХ	12.1	12.2	12.3	12.1	12.2	12.2
Зээлийн ЖДХ*	19.0	18.8	17.3	17.4	18.9	18.4
Ипотеклийн зээлийн ЖДХ	9.10	9.60	9.70	9.90	9.79	n/a
ТБҮЦ-ны ЖДХ	10.5	10.5	10.5	10.5	10.5	10.6
Бодлогын хүү	10.50	10.50	10.50	10.50	10.50	10.50
БХЗ-ын ЖДХ	9.90	9.64	9.13	8.91	9.48	9.78

* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2014 оны 2 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.9 хувь, оны эхнээс 2.7 хувь, өмнөх оны мөн үеэс 12.2 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 1.0 хувь, оны эхнээс 2.7 хувь, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 0.3 хувь, оны эхнээс 1.0 хувь, жилийн 13.1 хувь байв.

Тухайн сард мах, махан бүтээгдэхүүний үнэ 4.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 2.2 хувь, хүнсний ногоо 0.1 хувь, бусад хүнснийх 0.6 хувиар өсч хүнсний барааны бүлгийн үнэ 2.6 хувиар өссөн байна. Мөн хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.3 хувиар өссөн бөгөөд үүнээс тээврийн бүлэг 0.7 хувь (1л бензин, дизель түлш, тосны үнэ 1-1.4 хувь өссөн, 1 км таксины хөлс 14.3 хувь өссөн), хувцас, бөс барааны үнэ 0.6 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, сарын инфляцийн 77.8 хувийг хүнсний бараа (үүнээс, мах 84.6 хувь, сүү 9.4 хувь), 8.2 хувийг тээвэр, 7.9 хувийг хувцас, бөс барааны үнийн өсөлт бий болгожээ.




Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 67 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 32 бараа үйлчилгээнийх буурсан байна.

Жилийн инфляцид хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 10.1 хувь (жилийн өсөлтийн 27.4 хувь), хувцас, бөс бараа, гутал 14.7 хувь (жилийн өсөлтийн 15.6 хувь), боловсролын үйлчилгээ 28.4 хувь (жилийн өсөлтийн 14.1 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлш 11.9 хувь (жилийн өсөлтийн 13.2 хувь), гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 21.7 хувь (жилийн өсөлтийн 5.5 хувь), эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээ 21.6 хувь (жилийн өсөлтийн 4.8 хувь), тээвэр 4.6 хувь (жилийн өсөлтийн 4.6 хувь), зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 13.2 хувь (жилийн өсөлтийн 4 хувь), бусад бараа үйлчилгээ 22.7 хувиар (жилийн өсөлтийн 6.3 хувь) тус тус өссөн байна. Харин амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ 2 хувь, холбоо, шуудангийн үйлчилгээний үнэ 0.2 хувиар буурсан байна. Хүнсний барааны бүлгийн жилийн өсөлтийн 38.1 хувийг талх, гурилан бүтээгдэхүүн, 25.4 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 27.5 хувийг өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.


Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 1.8 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 36.1 хувиар өсч 9847.8 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 49.9 хувийг төгрөгийн хадгаламж, 20.6 хувийг валютын хадгаламж, 12.6 хувийг төгрөгийн харилцах, 11.7 хувийг валютын харилцах, 5.2 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.




Ипотекийн хөтөлбөрийг мөнгөний нийлүүлэлтээс хасч тооцвол мөнгөний нийлүүлэлт 21.3-36.1 хувийн хооронд өсөхөөр байжээ.



Тайлант сард гадаад валютын хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 17.8 нэгж хувиар нэмэгдэж харин гадаад валютын харилцахынх 0.8 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 3.9 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 4.8 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 9.9 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл гадаад валютын хадгаламж 116.7 тэрбум төгрөгөөр өссөн бол гадаад валютын харилцах 36.9 тэрбум төгрөг, төгрөгийн хадгаламж 51.9 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 103.2 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 104.8 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.



Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 46.8 хувийг төгрөгийн хадгаламж, 29.4 хувийг гадаад валютын хадгаламж, 13.3 хувийг гадаад валютын харилцах, 8.7 хувийг төгрөгийн харилцах, 1.8 хувийг

хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 0.9 хувь буюу 64.8 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 40.1 хувь буюу 1988.7 тэрбум төгрөгөөр өсч 6942.5 тэрбум төгрөг болов.




Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 2.4 хувь буюу 29.1 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 2.8 дахин их буюу 760.6 тэрбум төгрөгөөр өсч 1189.8 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.6 хувь буюу 22.8 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувь буюу 461.2 тэрбум төгрөгөөр өсч 3728.5 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 6.1 хувь буюу 116.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 61 хувь буюу 766.9 тэрбум төгрөгөөр өсч 2024.2 тэрбум төгрөг болжээ.



Нийт хадгаламжийн 70.8 хувь нь төгрөгийн, 29.2 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар буурсан байна.

Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 29.3 хувь, өмнөх оны мөн үеэс 79.2 хувиар буурч 843.9 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив өмнөх сараас 1.9 хувь, өмнөх оны мөн үеэс 2.8 дахин их өсч 9003.8 тэрбум төгрөг болов.



Нийт мөнгөний 8.6 хувь нь гадаад цэвэр активт, 91.4 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 5.9 хувь, өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар өсч 3131.1 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 16.9 хувь буюу 104.8 тэрбум төгрөг, банкуудын касс 12.1 хувь буюу 32.9 тэрбум төгрөгөөр буурсан бол Төв банк дахь харилцах, хадгаламж 15.1 хувь буюу 311.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар өсч 75.9 хувь болсон бол, банкуудын кассын эзлэх хувь 1.4 нэгж хувиар буурч 7.7 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 4.1 нэгж хувиар буурч 16.4 хувь болсон байна.

¹Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө

Зээл

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 2013 он гарсаар нэмэгдэж байгаа бөгөөд тайлант сард өмнөх сараас 1.3 нэгж хувиар өсчээ.

Хадгаламжийн байгууллагуудаас ¹ олгосон зээл өмнөх сарынхаас 1.3 хувь буюу 139 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 55.6 хувь буюу 3985.5 тэрбум төгрөгөөр өсч 11.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 2 хувь буюу 120.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 57.5 хувь буюу 2245.8 тэрбум төгрөгөөр өсч 6148.5 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 1.4 хувь буюу 67.3 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 52 хувь буюу 1684.7 тэрбум төгрөгөөр өсч 4925.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Харин хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол, иргэдийн зээлийн жилийн өсөлт 2014 оны 2 дугаар сарын байдлаар 19.1 хувь, хувийн хэвшлийн зээлийн жилийн өсөлт 39.3 хувьтай байхаар байжээ.

татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 55.1 хувь нь хувийн хэвшил, 44.2 хувь нь иргэд, 0.7 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 92.9 хувийг хэвийн зээл, 1.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.4 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.1 нэгж хувиар их байна.



Картын зээл

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.3 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл тайлант сард 253.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар буюу 84.6 тэрбум төгрөгөөр өсчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 0.6 хувиар буюу 1.6 тэрбум төгрөгөөр буурсан байна



Картын зээлийн 96.2 хувь нь хэвийн, 1.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.6 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 95.1 хувь нь төгрөгөөр, 4.9 хувь нь валютаар олгогдсон байна.

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2014 оны 2 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурч жилийн

